

“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2023 оны 10 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн хуралдааны тухай хуулийн 75¹ дүгээр зүйлийн 75^{1.1}-д заасныг баримтлан дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс агаарын хөлгийн I шатны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан инженер техникийн бүрэлдэхүүн, албан хаагчдыг II шатны сургалтад хамруулах, нисдэг тэрэгний хөдөлгүүрийг задалж, угсрах, техникийн үйлчилгээ, засварыг бие даан гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх, сургагч, инженер, ажилтнуудыг Монгол Улсад ажиллуулах, нисдэг тэрэгний сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээг хийх зайлшгүй шаардлага байгааг дурдаад, тус Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд эдгээр асуудлуудыг шийдвэрлэхээр тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал илэрхийлээгүй болно.

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ЦЭРЭНПУНЦАГ